



ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТСЛЭГ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 15, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-майл: info@pcsp.gov.mn,
Вебсайт: www.pcsp.gov.mn

2018. 06. 29 № A-112483

таний _____ -ны № _____ -т

Тогтоол хүргүүлэх тухай

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 273 дугаар тогтоолыг хүргүүлж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь холбогдох төрийн захиргааны байгууллага болон Та бүхэнтэй хамтран Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх (газар, барилга байгууламж) хөрөнгийн үнэлгээ, дахин үнэлгээг хийж санхүүгийн тайландаа тусгах ажлыг 2018 онд багтаан зохион байгуулахаар ажиллаж байна.


Мэргэжлийн зөвлөхүүдийн боловсруулсан газар, үл хөдлөх хөрөнгийн санхүүгийн тайлагналын зориулалттай үнэлгээ хийх аргачлалын төслийг батлуулахаар Сангийн яаманд хүргүүлээд байна.

Хөрөнгийн үнэлгээний болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлгээнд хамрагдах үл хөдлөх хөрөнгийг дансны нэг ангид бүртгэх зайлшгүй шаардлага гарч байна.

Иймд үнэлгээний ажил эхлэхээс өмнө буюу 2018 оны 8 дугаар сард багтаан энэхүү тогтоолыг орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг мэдэгдье.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 273 дугаар тогтоолыг тус газрын www.pcsp.gov.mn хаягаар байрлах цахим хуудаснаас татаж авна уу.

ДАРГА



Ц.НЯМ-ОСОР